



Хэвлэлийн мэдээ

2016 оны 4-р сарын 20-ны өдөр, Лхагва гараг

Холбогдох утас:

9710-9009

**Монгол дахь Америкийн Худалдааны Танхим
Уул уурхайн салбарын тэргүүлэх төлөөлөгч нартай уулзалт зохион
байгууллаа**

2016 оны 4-р сарын 20-нд Монгол дахь Америкийн Худалдааны танхим (АмЧам) нь Монголын уул уурхайн салбарын тэргүүлэх гурван төлөөлөгчид болох Энержи Ресурс ХХК-ийн Гүйцэтгэх захирал Г. Батцэнгэл, эдийн засагч, Монголын Шатдаг Занарын Ассоциацийн Гүйцэтгэх захирал Ч.Хашчулуун болон Эрдэнэс Монгол ХХК-ийн Ерөнхий эдийн засагч бөгөөд Оюу Толгой ХХК-ийн Удирдах зөвлөлийн гишүүн Ч.Отгочулуу нартай зохион байгууллаа.

Уулзалтанд АмЧамын гишүүд болон бизнесийн бусад төлөөлөл болох 60 гаруй бизнес эрхлэгчид оролцож Монгол улсын уул уурхайн салбарын томоохон төслүүдийг удирдаж буй албаны хүмүүсээс хамгийн сүүлийн үеийн мэдээлэл авсанаас гадна уул уурхайн салбарт тулгамдаж буй гол асуудлууд болон гарцуудын талаар хамтран ярилцаж сонирхсон асуултууддаа дэлгэрэнгүй хариулт авсан юм.

Эдийн засагч, Монголын Шатдаг Занарын Ассоциацийн Гүйцэтгэх захирал Ч.Хашчулуун уулзалтын үеэр хэлэхдээ “Монгол улс одоо л зөвхөн ганц уул уурхайн салбар бус эдийн засгийн бусад салбараа дэмжиж хөгжих хөгжлийн замыг сонгож эхлээд байна” гэсэн юм.

Эрдэнэс Монгол ХХК-ийн Ерөнхий эдийн засагч бөгөөд Оюу Толгой ХХК-ийн Удирдах зөвлөлийн гишүүн Ч.Отгочулуу уулзалтын үеэр хэлэхдээ “Эрдэнэс Монгол ХХК яг одоо засаглалын маш том шинэчлэл хийж байгаа, хэрэв энэ шилжилтийг бид сайн удирдаж чадвал компанийн зах зээлийн үнэлгээгээ өсгөж чадна” гэж онцлон тэмдэглэлээ.

Энержи Ресурс ХХК-ийн Гүйцэтгэх захирал Г. Батцэнгэл уулзалтын үеэр “Бид компаниа сурталчлах гэхээсээ илүүтэйгээр бидний хөрөнгө оруулагч, хувьцаа эзэмшигчдэд гол анхаарлаа төвлөрүүлж ирсэн. ММС компанид үүсээд буй нөхцөл байдал бол Монгол улсын дотоодод болж буй үйл явдлууд болон дэлхийн нүүрсний зах зээлд болж буй үйл явдлуудын л тусгал” юм гэв.

АмЧам Монгол нь АНУ-Монгол Улс хоорондын бизнесийн түншлэлийг өргөжүүлэх, бэхжүүлэх, эрх ашгийг нь хамгаалах болон Америкийн хөрөнгө оруулалтыг Монголд татах чиглэлээр ажилладаг бие даасан, гишүүддээ үйлчлэх төрийн бус байгууллага юм. АмЧам Монгол нь 3 сая гаруй гишүүдтэй дэлхийн хамгийн том бизнесийн холбоонд тооцогддог Америкийн Худалдааны Танхимын албан ёсны салбарын статустай. Мөн АмЧам Монгол нь Ази Номхон далайн 29 орнуудын Америкийн худалдааны танхимуудыг нэгтгэдэг Ази Номхон далайн орнуудын Америкийн Худалдааны Танхимуудын Зөвлөл байгууллагын гишүүн юм.